



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.1, 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зарласан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, албаны дарга В.Дарханбаатар нарыг томилсугай.

2.Төрийн өмчийн төлөөлөгчийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч нарт даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

130031427

\Huraldaanii material\2021 on\2021.04.21 6r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2021 оны 04 дүгээр сарын 27.-ны өдрийн
2021 дугаар тогтоолын хавсралт

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон дараах удирдамжийг баримтална:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-д заасны дагуу Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, дүгнэлт, салбарын яам болон төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг авсны үндсэн дээр “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ХХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлтийг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгч шийдвэр гаргах;

2. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тодотгол хийх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн батлах асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах;

3. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүтэц зохион байгуулалт, орон тоог шинэчлэн батлах асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах.

-----оо-----